

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 21 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10.00 цагт эхэлж, 11.00 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны газрын дарга нарын албан тушаалуудад томилогдох удирдах ажилтан нарт санал дүгнэлт гаргах тухай	1)Доржравдангийн Эрдэнэчимэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газрын; 2)Санжаагийн Наранцогтыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар санал, дүгнэлт гарган нэр дэвшүүлж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжавд санал болгосон тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргахаар тогтов.
2	Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд санал дүгнэлт гаргах тухай	1.Цэдэнсамбын Доржпаламыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар санал дүгнэлт гарган томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргав.
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын “мэргэжилтэн” ажлын байранд 2009 оны 5 дугаар сард зохиогдсон төрийн албаны мэргэшлийн шалгалтад орж тэнцсэн Г.Туяацэцэгийн тухай	1.2009 оны 5 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын “Хүн ам, гэр бүлийн хөгжлийн хэлтэс”-ийн “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн”-ний албан тушаалд өрсөлдөж 60.94 оноогоор тэнцсэн Гүрбазарын Туяацэцэгийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэснийг хавсралтаар батлах тухай МУ-ын ТА3-ийн тогтоол гаргав.
4	2009 оны 5 дугаар сард зохиогдсон Төрийн албаны мэргэшлийн шалгалтын үр дүн, зарим шийдвэрлэх асуудлууд	1)Аймаг дахь нутгийн захиргааны байгууллагуудын болон Замын-Үүд хилийн боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны сул орон тоог өдөр тутмын хэвлэлээр нийтэд зарлаж, төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэдээс нөхөх арга хэмжээ авах; 2)Аймаг дахь нутгийн захиргааны байгууллагуудын сул орон тоог нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх боломжгүй байгаа орон тоог

		нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2009 оны 11 дүгээр сард багтаан зохион байгуулахаар болов.
5	Бусад асуудал: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 54 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай	1.“Мэргэшлийн шалгалтын төв болон төрийн захиргааны төв байгууллагын салбар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын бүрэлдэхүүн”-ын “Нарийн бичгийн дарга: -Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны шинжээч Б.Идэрчулуун” гэсэн хэсгийг “Нарийн бичгийн дарга: -Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны ахлах шинжээч Т.Сосорбарам” гэж өөрчлөх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
